

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 06 сарын 08-ны өдрийн 01/35 тоот албан бичгийн дагуу Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2021 оны 06 сарын 09-ны өдрийн 01/13 тоот удирдамжийн хүрээнд Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2020-2021 оны хичээлийн жилийн аж ахуйн болон бараа материалын тайланд Монгол Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 347 тоот тушаал, бусад холбогдох дүрэм журмын хүрээнд шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд, дотоод аудитор С.Бямба-Очир нар 2022 оны 06 сарын 10-ны өдрөөс ажлын 14 өдөр шалгалт хийлээ. Шалгалтын дундуур Сайхан сумын төсвийн байгууллагуудыг шалгах ажлаар 6 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 27-ны өдөр хүртэл томилолтоор ажилласан. Нярав П.Бямбасүрэн 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 7 дугаар сарын 7-ны өдөр хүртэл ажлын 2 өдрийн чөлөө авч хот явсан зэргээс хамаарч шалгалтын хугацаа сунгагдсан.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус цэцэрлэгийн 2021-2022 оны хичээлийн жилийн үдэж архивласан харилцахын 4 ширхэг баримт, бараа материалын тайлан 6 ширхэг, багшийн ирцийн журнал 9, агуулахын бүртгэл, дээжийн бүртгэл зэргийг тулган шалгаж агуулахын үлдэгдэлийг тоолсон.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган сумын 2 дугаар цэцэрлэг нь эрхлэгч 1, арга зүйч 1, нягтлан бодогч 1, нярав 1, бага эмч 1, бүлгийн багш 9, туслах багш 10, бүжгийн багш 1, ахлах тогооч 1, туслах тогооч 1, гал тогооны бэлтгэгч 1, угаагч 1, үйлчлэгч 1, жижүүр 3 нийт 33 орон тоотой 8 бүлэгтэй үйл ажиллагаа явуулж байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын газраас 2021 оны санхүүгийн тайланд аудитаар зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Төрийн аудитын газрын 2022.02.25-ны өдрийн 01/214 тоот албан шаардлагаар төсвөөс 2000.0 мянган төгрөгийн 11 ширхэг сандал худлдан авсан нь Засгийн газрын 2021 оны Төсвийн талаар авах арга хэмжээний тухай 43-р тогтоолын 1.4 дахь заалтыг зөрчсөнг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллан албан шаардлагын биелэлтийг 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитад ирүүлэхийг даалгасан байна

Төрийн аудитын газрын дугааргүй албан шаардлагаар хүүхдийн тоглоом худалдан авахдаа гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй бараа бүтээгдэхүүнээ хугацаандаа аваагүйгээс, төсвийн шууд захирагч төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй дахин 1863.4 мянган төгрөгөөр авлага үүсгэсэн тусвийн тухай хуулийн 6.4.8 төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчмыг хэрэгжүүлж албан шаардлагын биелэлтийг гаргаж 6 дугаар сарын 10-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг даалгасан байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус Цэцэрлэгийн харилцах дансны гүйлгээг бараа материалын тайлантай нэг бүрчлэн байгууллага иргэн тус бүрээр тулган, багшийн ирцийн журналыг бүлгийн багш нарын бүртгэлтэй цахим тулгалт хийж, хүнс, аж ахуйн материалын үлдэгдэлийг тоолсон. /Хүснэгтийг хавсаргав/

2022 оны 01 дүгээр сараас 05 сарын 30-ныг хүртэлх хугацаанд Очир шонхор ХХК-аас 11736.3 мянган төгрөг, Баянцэнгөрөг ХХК-аас 8624.2 мянган төгрөг, Булган милкээс 1272.0 мянган төгрөг, Ачуут мөнх агро ХХК-аас 3287.8 мянган төгрөг, Булган маргадаас 3687.2 мянган төгрөг нийт 28607.5 мянган төгрөгийн хүнсний материал, бусад хангамжийн материал 4928.2 мянган төгрөгийг шилжүүлж, няравын хүнсний тайлангаар Очир шонхор ХХК-аас 11828.4 мянган төгрөг, Баянцэнгөрөөс 8865.7 мянган төгрөг, Булган милкээс 1272.0 мянган төгрөг, Ачуут мөнх агрогоос 2685.8 мянган төгрөг, Булган маргадаас 3687.2 мянган төгрөг нийт 28339.1 мянган төгрөгийн хүнс орлогодож хүнсний өдөрлөгөөр 26013.0 мянган төгрөгийн хүнсний материал зарцуулсан байна. Шалгалтын хугацаанд 10 багш, ажиллагсадаас үндсэн баримтыг үзүүлж тайлбар авсан. /Холбогдох судалгааг анхан шатны баримтаас гаргасан/

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Одод бүлэгт 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс 30-ны өдөр хүртэл 3 хоног хичээллээгүй бүртгэлтэй байхад хүүхдийн хоолны өдөрлөгөөр 26 хүүхдийн хоолны материалд 31540 төгрөг илүү зарцуулсан.

2. Булган эм хангамж□□□ийн байгууллагаас 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 1100.0 мянган төгрөгийн дөрвөн нэр төрлийн материалуудыг худалдан авсан байхад 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдөр шаардах хуудасаар бөөн дүнгээр, өмнөх өдрөөр зарлагдсан.

3. Хүнсний 12 дугаар сарын тайланд дун гоймон 2 ширхэгийг 20000 төгрөгөөр, шпагита гоймон 10 ширхэгийг 25000 төгрөгөөр нийт 45000 төгрөгийн хүнсний материалыг орлогод авсан байхад анхан шатны баримт болох орлогын баримт байхгүй.

4. Хүнсний материалын агуулахын бүртгэлийг буруу хөтөлсөн, бусад бараа материалд агуулахын бүртгэл хөтөлдөггүй,

5. Нягтлан бодогчоор ажиллаж байсан Э.Сайнчимэг 3,4-р саруудын бараа материалын тайланг хянаж хүлээж аваагүй.

6. Өдөрлөгийн тоо засварласан, агуулахын бүртгэл, өдөрлөгийг арилгадаг балаар бичсэн, өдөрлөгт цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч гарын үсэг зураагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д/үнэн зөв байх/, 13 дугаар зүйлийн 13.1-т /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.5-д /Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна/, 13.6-д /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/

7. Баталсан хоолны цэснээс хүнсний өдөрлөгийн материал зөрүүтэй бичигдсэн. Тухайлбал: 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн баталсан өдөрлөгөөр үзэмний шүүс, буржгар гоймонтой шөл, хонин бууз, цай, печень, тасалсан гурилтай шөл байхад гурил бичигдээгүй.

8. Хүнсний материалын тайланг зөрүүтэй гаргаснаас 2022 оны 2-р сард 39071 төгрөг илүү, 550 төгрөг дутуу, 11000 төгрөгийн үнэтэй үхрийн мах үлдэгдэлгүй байхад 31.5 кг-ийг зарлагдсан, 3-р сард нийт дүнгээрээ 45000 төгрөг илүү, 20800 төгрөг дутуу тайлагнасан байна.

9. Хүнсний материалын тайлангийн үлдэгдэлээр 90 нэр төрлийн 6079224 төгрөгийн үлдэгдэлтэй тооцоо гарч байхад тооллогоор 32 нэр төрлийн 1784230 төгрөгийн материал тоологдож, 36 нэр төрлийн 2383360 төгрөгийн буцаалт хийгдэж, 51 нэр төрлийн 2194436 төгрөгийн хүнсний материалын дутагдаж, 8 нэр төрлийн 239650 төгрөгийн материалын илүүдэл гарсан.

10. Санхүүгийн тайлангийн бичиг хэргийн материал эхний үлдэгдэл 1191500 төгрөг байхад няравын бичиг хэргийн материалын эхний үлдэгдэл 1195500 төгрөг зөрүү 4000 төгрөг, аж ахуйн материалын эхний үлдэгдэл 15016312.88 төгрөг няравын тайлагийн эхний үлдэгдэл 14929312.88 төгрөг зөрүү 87000 төгрөгөөр, бусад хангамжийн материалын эхний үлдэгдэл 36598017.50 төгрөг няравын тайлангийн эхний үлдэгдэл 36695017.50 төгрөг зөрүү 97000 төгрөг нийт 101000 төгрөгөөр илүү, 87000 төгрөгөөр дутуу байна.

11. Төрийн сангийн бүртгэлийн дансны хуулгаар 3-р сард аж ахуйн материалд 7 бэлтгэн нийлүүлэгч рүү 1911450 төгрөг шилжүүлж няравын тайлангаар 1215250 төгрөгийн материал орлогод авч, 1029900 төгрөгийн материал зарцуулсан тайлан гаргасан ч анхан шатны баримт хавсаргаагүй.

НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Шалгалтын хугацаанд санхүү бүртгэлийн ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын байцаагчийн 3 актаар 2465.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, гарсан зөрчлийг арилгуулахаар албан шаардлага бичлээ. Шалгалтын хугацаанд актаар тогтоосон төлбөрөөс 2194.4 төгрөг барагдсан.

ЕС. ДҮГНЭЛТ

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.2-д /батлагдсан маягт, зааврын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайланг гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах/, 19.1.3-д /нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах/, 19.1.4-д /эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ зэрэг заалтуудын хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал гарах нөхцөл бүрдсэн байна.

АРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуул болон боловсрол, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайд, сангийн сайдын хамтарсан А/166, А/559, 222 тоотоор баталсан нормативыг мөрдөж ажиллах.

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж хэвшүүлэх

Илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй таслан зогсоох талаар тодорхой ажил зохион байгуулах.

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Л.ЦЭРЭНБҮТЭД
ДОТООД АУДИТОР С.БЯМБА-ОЧИР

ХЯНАСАН: СХДАА-НЫ ДАРГА

Б.БАТТУЛГА